



**№1.42.МАЛД ҮЗЛЭГ АНГИЛАЛТ, ХЯНАН
БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН АЖЛЫГ ШАЛГАХ
ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хяналтын байгууллага:

Шалгуулагч этгээдийн нэр:

Объектын нэр:

Регистрийн дугаар:

Хяналт шалгалт хийсэн огноо:/.../..

Шаардлага хангасан асуултын тоо:

Хууль сахин мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй нийт оноо:

Эрсдэл үүсэх магадлалын хувь:

Эрсдэл үүсэх магадлал

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
	1	2	3	4	5	6
Нэг. Хуулийн хамаарах заалтууд			0	80	0	0
1	Малын генетик нөөцийн тухай хууль 11.6	Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж нь тухайн сум, дүүргийн Засаг дарга, үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулж ажилладаг;	0	10		
2	Малын генетик нөөцийн тухай хууль 11.6.2	Баталгаажсан үүлдэр, омгоос цөм сүрэг бүрдүүлдэг;	0	10		
3		Өсвөр малыг үржилд шилэн сонгодог;	0	10		
4		Ялган суурилалт хийдэг;	0	10		
5		Хээлтэгч, хээлтүүлэгчийг үржлийн нас хүртэл бойжуулж, борлуулдаг;	0	10		
6	Малын генетик нөөцийн тухай хууль 11.6.3	Технологийн зохистой хугацаанд үзлэг ангилалт хийдэг;	0	10		
7		Тохируулан сонголт хийдэг;	0	10		
8		Үржлийн бүртгэл хөтөлдөг;	0	10		
Хоёр. Адуу, үхэр, хонь, ямаа ангилах заавар. ХХААХҮ-ийн сайдын тушаал. 2011 он. А/76.			0	280	0	0

9		Мал ангилалтыг эрх бүхий төр захиргааны шийдвэрээр малчид, мэргэжилтнийг оролцуулсан комиссыг байгуулж, ангилалт хийх хуваарь, төлөвлөгөө гаргаж ажилладаг;	0	5		
10		Ангилалтыг ангилагч /шинжээч/ мал зүйч буюу тухайн төрлийн малын үржил-селекцийн ажилд дадлага туршлагатай, мэргэшсэн мал зүйчид гардан хийдэг;	0	5		
11	ХХААХҮ-ийн сайдын 2011 оны А/76 тушаал "Адуу, үхэр, хонь, ямаа ангилах заавар" Ангилалтын зохион байгуулалт	Ангилалт хийхэд шаардагдах хашаа байр, унаа хөсөг, ажиллах хүн хүч, хэрэглэгдэх журнал, ээмэг, бахь бусад багаж хэрэгслийг бүрэн хангасан;	0	5		
12		Ангилалтын эцэст цөм сүргийн малын анги чанар, нас, хүйс, үржлийн болон хэрэгцээний хэсэг гэсэн товчоо гарган урьд жилийн тохируулан сонголтын үр ашгийг дүгнэж акт бичдэг;	0	5		
13		Аж ахуйн нэгж, малчид, ард иргэдэд өөрсдийн сүргээс дээд ангид орсныг үржилд ашиглах, эсвэл үржилд борлуулах, доод анги буюу хэрэгцээний хэсгийг хүнсний зориулалтаар борлуулах талаар ангилалтын дүнг ашиглан зөвлөмж бичиж үлдээдэг;	0	5		
14		ХХААХҮ-ийн сайдын 2011 оны А/76 тушаал "Адуу, үхэр, хонь, ямаа ангилах заавар" Үржлийн тоо бүртгэл	Үржлийн шилмэл буюу 1 дүгээр ангийн хээлтэгч, хээлтүүлэгчийг үр төлөөр нь шалгасан сүрэг түүний үр төл бүрт нэгбүрчилсэн бүртгэл хөтөлдөг;	0	10	
15		Үржлийн хээлтэгч, хээлтүүлэгчийн гэрчилгээтэй;	0	10		
16	ХХААХҮ-ийн сайдын 2011 оны А/76 тушаал "Адуу, үхэр, хонь, ямаа ангилах заавар" Хувьсын бүртгэл хөтлөлт	Үржлийн малын хувьсын ангилалт, ашиг шимийн мэдээллийн бүртгэлтэй;	0	10		
17		Төллөлт, хээлтүүлгийн бүртгэлтэй;	0	10		
18		Тохируулан сонголтын бүртгэлтэй;	0	10		
19		Хээлтүүлэгч ашиглалтын бүртгэлтэй;	0	10		
20		Тухайн жилийн ангилалтын бүх материалыг урд жилүүдийн материалтай харьцуулан дүгнэдэг;	0	5		

21	ХХААХҮ-ийн сайдын 2011 оны А/76 тушаал "Адуу, үхэр, хонь, ямаа ангилах заавар" Ангилалтын дүн	Удмуудын доторх тохируулан сонголт, хээлтүүлэгчийг үр төлийн чанараар үнэлэх үнэлэлт, сүрэг сэлбэх өсвөр хээлтүүлэгчийн сонголтоор үржлийн ажлын хэтийн төлөвлөгөөний биелэлтэд дүн шинжилгээ хийдэг;	0	5		
22	ХХААХҮ-ийн сайдын 2011 оны А/76 тушаал "Адуу, үхэр, хонь, ямаа ангилах заавар" Ангилалтын дүн	Ангилалтын материалыг үндэслэн ирэх жилийн хээлтүүлгийн төлөвлөгөөг урьдчилан боловсруулдаг;	0	5		
23		Хувьсын ангилалтанд орсон малын ашиг шимийн үндсэн үзүүлэлтийг мэдээллийн гэрчилгээнд бичдэг;	0	5		
24		Таваарын аж ахуйд ангийн ангилалт хийдэг;	0	5		
25	ХХААХҮ-ийн сайдын 2011 оны А/76 тушаал "Адуу, үхэр, хонь, ямаа ангилах заавар" Ангилалтын нэгдсэн дүн	Малын нас, хүйс /үүлдэрээр/-ээр ангилдаг;	0	5		
26		Ангилалтанд орсон малын тоогоор ангилдаг;	0	5		
27		Шилмэл цөм сүргийн тоогоор ангилдаг;	0	5		
28		Үржлийн үндсэн сүргийн I ангийн тоогоор ангилдаг;	0	5		
29		Үржлийн үндсэн сүргийн II ангийн тоогоор ангилдаг;	0	5		
30		Үржлийн үндсэн бүх сүргийн тоогоор ангилдаг;	0	5		
31		Хэрэгцээний сүргийн доод ангиар ангилдаг;	0	5		
32		Хэрэгцээний сүргийн доод заазаар ангилдаг;	0	5		
33	Хэрэгцээний сүргийн эр, сувайгаар ангилдаг;	0	5			
34	Хэрэгцээний бүх сүргээр ангилдаг;	0	5			
35		Үржлийн хээлтүүлэгч, хээлтэгч, өсвөр малд /байдас, гунж, дөнж, охин төлөг, борлон/ ангилалт хийж үр төлөөр шалгасан хээлтүүлэгчийн болон шилмэл, I ангийн малын төлд үзлэг хийж үр төлийн гарал, үүслийн нарийн бүртгэл хөтөлж эцэг, эхийн гарваль, ашиг шим, хувийн дугаарыг тавьдаг;	0	10		
36	ХХААХҮ-ийн сайдын 2011 оны А/76 тушаал "Адуу, үхэр, хонь, ямаа ангилах заавар" Аж ахуйн нэгжид	Шилмэл ба I ангийн хээлтүүлэгч, хээлтэгч, сүрэг сэлбэх охин мал, түүний төл, үр төлөөр шалгасан хээлтүүлэгчийн төлийн жин, ашиг шимийн гарцыг нэгбүрчлэн тодорхойлдог;	0	10		

37	явуулах үржлийн ажил	Хуц, ухныг үр төлөөр шалгаж, удмын үржүүлэг явуулдаг;	0	10		
38		Үржлийн бүх хуц, ухнанд хавар ноолуур самнах, хонь хяргахын өмнө, намар хээлтүүлгийн өмнө 2 удаа үзлэг хийдэг;	0	10		
39		Үржлийн хонь, ямааны хурга, ишгийг эхээс төрөх, 20 хоногтой, эхээс ялгаж үед үзлэг хийж ноос, ноолуурын чанар, урт, бие бялдар, жин, хэвшлийг тодорхойлж, эр ишиг, хургыг засаж хөнгөлдөг;	0	10		
40		Хэрэгцээний чиглэлийн аж ахуйн нэгжид цэвэр үржүүлгийн болон эрлийзжүүлгийн аргыг хэрэглэдэг;	0	10		
41		Сүргийн ашиг шимийг дээшлүүлэхийн тулд тухайн үүлдрийн хээлтүүлэгчийг өөр аж ахуйгаас авч ашигладаг;	0	10		
42	ХХААХҮ-ийн сайдын 2011 оны А/76 тушаал "Адуу, үхэр, хонь, ямаа ангилал заавар" Хэрэгцээний	Охин төлөг, борлон, төлгөн хуц, борлонд ангилалт хийж бүртгэл хөтөлдөг;	0	10		
43	чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид	Үржлийн хуц, ухнанд хавар, намар 2 удаа үзлэг хийдэг;	0	10		
44	явуулах үржлийн ажил	Шилмэл ба I ангийн мал нэг бүрийг им, ээмэгтэй болгосон;	0	10		
45		Тухайн малын ашиг шимийн дундаж үзүүлэлтийг аж ахуйн нэгж, суурийн дунджаар гаргадаг;	0	10		
46		Үржлийн болон өсвөр малыг нэмэгдэл тэжээлтэйгээр маллаж, өвөлжүүлж, хаваржуулдаг;	0	10		
Гурав. Дотоод хяналт			0	27	0	0
47	Төрийн хяналт шалгалтын тухай хууль 7.2, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлуулан мөрдөж ажилладаг	0	9		
48		Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авч	0	9		
49		Дотоод хяналт шалгалтын тайлан гаргадаг	0	9		
НИЙТ ОНОО			0	387	0	0

БАТАЛГААЖУУЛАЛТ		
Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан

<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>
<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тамга/</i>

Тайлбар: